



**АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/300

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит
үйлдвэрийн газрын ажилтан сонгон
шалгаруулах журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.10.7, 6.12 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын гурав дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллахыг Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтэс /Б.Баатарцол/, Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн төв, Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, аймгийн Автотээврийн төв, Замын-Үүд, Цогтцэций салбарын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ




Б.ГҮРСОРОНЗОН

000001334



“Автотээврийн үндэсний төв” төрийн
өмчит үйлдвэрийн газрын захирлын
2022 оны 14 дугаар сарын 08 -ны
өдрийн 14 дугаар тушаалын хавсралт

1300.



БАРИМТЖУУЛСАН ЖУРАМ
ЗСХНХ 08-12-2022

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Боловсруулсан:	Хянасан:
	
ЗСХНХ-ийн ахлах мэргэжилтэн Ц.Хонгорзул	ЗСХНХ-ийн дарга Б.Баатарцол

ЭХ ХУВЬ

МӨРДӨЖ ЭХЭЛСЭН ОГНОО: 2022.12.08
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО:
ӨӨРЧЛӨЛТИЙН № 00

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №2/8
	Өөрчлөлтийн огноо:	

ГАРЧИГ

Нэг.Нийтлэг үндэслэл	4
Хоёр.Сонгон шалгаруулалтын зарчим	4
Гурав.Сонгон шалгаруулалтыг мэдээлэх.....	5
Дөрөв.Сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх	6
Тав.Сонгон шалгаруулалтын арга, үе шат	6
Зургаа.Сонгон шалгаруулалтын дүн гаргах	7
Долоо.Үйлдвэрийн газрын хүний нөөц бүрдүүлэх	7
Найм.Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг ажлын байранд томилох шийдвэр	8
Ес.Бусад зүйл	8

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №3/8
	Өөрчлөлтийн огноо:	

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

НЭГ.НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1.Хөдөлмөрийн тухай хууль, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар /цаашид үйлдвэрийн газар гэх/-ын Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг үндэслэн үйлдвэрийн газрын удирдах албан тушаал, мэргэжлийн албан тушаал, техникийн гүйцэтгэх албан тушаал, туслах албан тушаал /цаашид “үйлдвэрийн газрын ажилтан” гэх/-д томилогдох ажилтныг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2.Үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалд томилогдох иргэнийг сонгон шалгаруулах ажлын зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилго, зорилт, чиг үүргийг мэргэжил, мэргэшлийн болон ёс зүйн өндөр түвшинд хэрэгжүүлэх ажилтныг шилж сонгоход оршино.

ХОЁР.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЧИМ

2.1.Үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалд томилогдох иргэнийг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

2.2.Ил тод байдал, тэгш эрх, шударга ёсыг хангах, хараат бус байх, нууцыг хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, шударга өрсөлдөөний зарчмыг баримтална.

2.3.Үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалд томилогдох иргэнийг сонгон шалгаруулахад үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харъяалал зэргээр ялгаварлаж болохгүй.

2.4.Үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаалын зорилго, зорилт, гүйцэтгэх чиг үүрэг, хүлээх хариуцлага болон дор дурдсан шалгуурыг хангасан ажилтныг сонгон шалгаруулж ажилд томилно. Үүнд:

- 1/тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг;
- 2/боловсролын түвшин;
- 3/мэргэжил;
- 4/ажлын туршлага, мэргэшлийн ур чадвар.

2.5.Үйлдвэрийн газрын удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд:

1/үйлдвэрийн газарт ажиллаж байгаа албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, сул байгаа албан тушаалд бэлтгэгдсэн байдал, мэргэшлийн түвшингээр нь 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж, сонгон шалгаруулалтын дүгнэлтийг үндэслэн албан тушаал дэвшүүлэх замаар уг орон тоог нөхөж болно.

2/энэ журмын 2.5-ын 1-д заасны дагуу тухайн орон тоог нөхөх боломжгүй тохиолдолд уг ажлын байранд ажиллах албан тушаалтныг энэхүү журмын **гурав, дөрөв, тав, зургаа-д** заасны дагуу сонгон шалгаруулна.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №4/8
	Өөрчлөлтийн огноо:	

ГУРАВ.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ МЭДЭЭЛЭХ

3.1.Үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалын сул орон тоог сонгон шалгаруулалт явуулахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө тухайн албан тушаалын талаар болон бусад холбогдох мэдээллийг үйлдвэрийн газрын www.transdep.mn сайт, дотоод цахим сүлжээ, пэйж хуудас, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

3.2.Ажлын байрны сул орон тоог хүний нөөц хариуцсан нэгж, аймгийн Автотээврийн төв, салбар мэдээлнэ.

3.3.Мэдээлэлд нэр дэвшигчид тавих болзол, шаардлага, бүрдүүлэх материал, сонгон шалгаруулах ажлын хэсэг /цаашид "ажлын хэсэг" гэх/-ийн хаяг, харилцах утасны дугаар, материал хүлээн авах, бүртгэх болон сонгон шалгаруулалт явуулах байр, хугацаа зэргийг заана. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд сонгон шалгаруулах ажлын хэсэг тухай бүрд нь мэдээлж байна.

3.4.Үйлдвэрийн газрын алба, хэлтэс, Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн төв, Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн ажилтны албан тушаалд томилогдох иргэнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг захирлын, аймгийн Автотээврийн төв, салбарын ажилтны албан тушаалд томилогдох иргэнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг тухайн төв, салбарын даргын шийдвэрээр ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга /хүний нөөцийн мэргэжилтэн, (аймгийн Автотээврийн төв, салбар) нярав, бичиг хэрэг/-ыг оролцуулан 3–аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Ажлын хэсгийг дарга ахалж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оруулна.

3.5.Ажлын хэсгийг сонгон шалгаруулалт явуулах бүрт шинээр байгуулна.

3.6.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.7.Ажлын хэсэг нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/нэр дэвшигчийн материалыг хүлээн авч, хянан нэгтгэх;

2/сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

3/сонгон шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргах;

4/ сонгон шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлж байх;

5/сонгон шалгаруулалт явуулах байр, бусад шаардагдах нөхцөлийг хангах;

6/сонгон шалгаруулалт явуулсан тухай тайланг тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтын хамт захиралд танилцуулах.

3.8.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/сонгон шалгаруулалттай холбогдсон асуудлаар ажлын хэсгийн даргыг тухай бүр холбогдох мэдээллээр хангах;

2/сонгон шалгаруулалттай холбогдсон санал, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлж байх;

3/ажлын хэсгийн хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, шийдвэрийг нь зохих журмын дагуу баталгаажуулах;

4/сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлангийн төсөл бэлтгэх;

5/сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу цэгцэлж архивт шилжүүлэх.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №5/8
	Өөрчлөлтийн огноо:	

ДӨРӨВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧИЙГ БҮРТГЭХ

4.1.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэдээс дор дурдсан материалыг тогтоосон хугацаанд хүлээн авч бүртгэнэ:

1/биеийн байцаалт (Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт 1-ийн дагуу);

2/ боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /E-Mongolia цахим мэдээллийн сангийн тодорхойлолт/;

3/Монгол Улсын иргэний үнэмлэхний хуулбар /E-Mongolia цахим мэдээллийн сангийн тодорхойлолт/;

4/ажил эрхэлдэг бол ажил байдлын тодорхойлолт;

5/туслах албан тушаалын ажилтнаас бусад албан тушаалд томилогдох ажилтан бол эрх бүхий байгууллагын тодорхойлолт /гэмт хэрэгт холбогдож байгаагүй, тус үйлдвэрийн газарт ажиллаж байсан иргэний хувьд сахилгын арга хэмжээгээр ажлаас халагдаагүй байхыг шаардана/;

6/4х6-ийн хэмжээтэй 2 хувь зураг.

4.2.Энэ журмын 4.1-д заасан материалыг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй

ТАВ.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА, ҮЕ ШАТ

5.1.Үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалд ажиллах хүсэлт ирүүлсэн иргэний биеийн байцаалт, холбогдох бусад материалыг тухайн албан тушаалд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагатай харьцуулах замаар эхний шалгаруулалт явуулна.

5.2.Эхний шалгаруулалтад тэнцсэн иргэдийг дараахь хэлбэрээр сонгон шалгаруулна:

1.ур чадварын түвшин тогтоох;

2.ярилцлага хийх;

3.эрүүл мэндийн үзлэг.

5.3.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтыг дор дурдсан байдлаар зохион байгуулна:

1/Үйлдвэрийн газраас тогтоосон өдөр, цагт багтаан ур чадварын түвшинг тогтоож, ярилцлагыг явуулж, дүгнэх;

2/ур чадварын түвшинг хангасан, ярилцлагад тэнцсэн иргэнийг магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын үзлэгт оруулж, эрүүл мэндийн дүгнэлт гаргуулах.

5.4.Энэ журмын 5.3.1-д заасан шалгаруулалтыг тухайн албаны тушаалын ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан захирлын шийдвэрээр томилсон мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг /комисс/ зохион байгуулна.

5.5.Энэ журмын 5.4-т заасан ажлын хэсэг /комисс/ нь мэргэжлийн ур чадвар тогтоох шалгалт авах материал /тест, даалгавар, эссэ, кейс/-ыг боловсруулна.

5.6.Эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар баталсан “Эрүүл мэндийн бүртгэлийн маягт”-аар баталгаажсан байна.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №6/8
	Өөрчлөлтийн огноо:	

ЗУРГАА. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮН ГАРГАХ

6.1. Сонгон шалгаруулалтын дүнг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн зохих шийдвэр гаргана. Ажлын хэсгийн хуралдааны шийдвэрийг 2 хувь үйлдэж, ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурна.

6.2. Аймгийн автотээврийн төв, салбар нь ажлын хэсгийн тайлангаа хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж тайланг хүлээн авч дүгнэлт гарган, захиралд танилцуулна.

6.3. Ажлын хэсгийн дарга сонгон шалгаруулалт явуулсан тухай тайланг сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтын хамт захиралд танилцуулна.

6.4. Захирал болон ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг судалж, магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдээс тодорхойлолт гаргуулж болно.

6.5. Сонгон шалгаруулалтад тэнцсэн буюу хангалттай оноо авсан иргэн нь үйлдвэрийн газрын захирал, нэгжийн удирдлагуудтай уулзалт хийх бөгөөд захирал тухайн албан тушаалд томилох эсэх эцсийн шийдвэрийг гаргана.

6.6. Ажлын хэсэг нь тухайн албан тушаалын шаардлагыг хамгийн сайн хангаж байгаа нэр дэвшигчээс эхлэн томилох тухай нэр дэвшүүлнэ.

6.7. Захирал нь ажлын хэсгийн тайлантай танилцаж, ажлын хэсгийн санал, өөрийн явуулсан судалгаа, холбогдох этгээдийн тодорхойлолт зэргийг харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан иргэнийг албан тушаалд томилох, бусад иргэнийг албан тушаалтны нөөцийн жагсаалт /цаашид хүний нөөцийн бүртгэл гэх/-д оруулах тухай шийдвэрийг гаргана.

6.8. Захирал ажлын хэсгийн санал болгосон нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилохоос татгалзсан тохиолдолд энэ тухайгаа зохих үндэслэлийн хамт нэр дэвшигчийн материалыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигчид албан бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд ажлын хэсэг нь тухайн сонгон шалгаруулалтад тэнцэж хүний нөөцийн жагсаалтад орсон иргэдээс нэр дэвшүүлэх, эсхүл сонгон шалгаруулалтыг дахин явуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.9. Сонгон шалгаруулалтаас гарсан үр дүнг ажлын 5 хоногийн дотор сонгон шалгаруулалтад орсон иргэдэд өөрт нь биечлэн болон утсан холбоо, цахим хаягаар хүргэнэ.

6.10. Захирал үйлдвэрийн газрын хүний нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн иргэдээс үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалд томилох шийдвэр гаргаж болно.

ДОЛОО. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ

7.1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг хүний нөөцийн бүртгэлд оруулах тухай шийдвэр 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

7.2. Хүний нөөцийн бүртгэлд бүртгэлтэй иргэн өмнөх сонгон шалгаруулалтад өрсөлдсөн албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд энэ журмын 7.1-д заасан хугацааны дотор шууд нэр дэвших эрхтэй. Харин өмнөх сонгон шалгаруулалтад өрсөлдсөнөөс өөр албан тушаалд ажиллахыг хүсвэл сонгон шалгаруулалтад дахин орно.

7.3. Энэхүү журмын гуравдугаар зүйлд заасан мэдээний дагуу сонгон шалгаруулалтад оролцох иргэн бүртгүүлээгүй томиолдолд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний нэгжид ажлын байр идэвхтэй

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №7/8
	Өөрчлөлтийн огноо:	

хайгчдын бүртгэл болон үйлдвэрийн газрын хүний нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн иргэдээс тухайн сул ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлага хангасан иргэнийг үйлдвэрийн газрын ажилтны албан тушаалд томилж болно.

НАЙМ.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТЭНЦСЭН ИРГЭНИЙГ АЖЛЫН БАЙРАНД ТОМИЛОХ ШИЙДВЭР

8.1.Сонгон шалгаруулалтын бүх шатанд тэнцсэн иргэнтэй туршилтын хугацаагаар болон ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтныг ажлын байрандаа үргэлжлүүлэн ажиллах хүртэлх хугацаанд томилох, үндсэн ажилтнаар томилох эсэхийг захирал шийдвэрлэнэ.

8.2.Зарим ажлын байранд “Баримжаа олгох сургалт”-д хамруулна.

8.3.Туршилтын хугацаа дууссан ажилтны гүйцэтгэсэн ажлын тайланг хүний нөөцийн нэгж болон тухайн үйл ажиллагааны чиг үүргийг хариуцах нэгжийн хурлаар хэлэлцэн хурлын тайлангийн хамт захиралд танилцуулна.

8.4.Туршилтаар болон түр ажиллаж буй ажилтан гүйцэтгэсэн ажлын тайланг 3-аас илүүгүй хуудастай байхаар бэлтгэх ба дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Өөрийн товч танилцуулга
- Туршилтын хугацаанд хийсэн гол ажил
- Үйлдвэрийн газарт ажиллахад төрсөн сэтгэгдэл, байгууллагын соёлд дасан зохицсон байдал
- Цаашид хийхээр төлөвлөж буй ажил, санал санаачилга.

8.5.Ажилтан гүйцэтгэсэн ажлын тайланг 15 минутаас хэтрэхгүй хугацаанд танилцуулах бөгөөд асуулт, хариулт болон шийдвэрлэх хугацаатай нийлээд 30 минутаас илүүгүй байна.

8.6.Гүйцэтгэсэн ажлын тайлангийн дүгнэлтээр туршилтын хугацаанд хангалттай үр дүн гаргаагүй, байгууллагын дотоод журам, соёлд дасан зохицож чадаагүй ажилтныг тухайн ажлын байранд тэнцээгүй гэж үзнэ.

ЕС.БУСАД ЗҮЙЛ

9.1.Албан тушаалтныг сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-12-2022	“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2022.12.08	Өөрчлөлт №00	Хуудас №8/8
	Өөрчлөлтийн огноо:	